БАТЛАВ.
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР

2021 оны 04 дүгээр сарын 8...өдөр

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээ | Хугацаа | Шаардлагатай төсөв /төгрөгөөр/ | Хариуцах нэгж | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр | | | | | |
| 1 | Албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг харгалзан мөнгөн урамшуулал, ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийг нэмэгдүүлэх, олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх | Улирал тутам | 1,422.319,800 | Захиргаа, удирдлагын газар, Санхүүгийн хэлтэс | Албан хаагчдад хууль тогтоомжийн хүрээнд зэрэг дэв, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллыг олгосноор ажлын гүйцэтгэл, үр дүнд ахиц гарна. |
| 2 | Албан хаагчдын орон сууц барих ажлыг судлах, холбогдох саналыг боловсруулах | Жилдээ | Төсөв шаардахгүй | Ажлын хэсэг | Ажлын хэсгээс орон сууц барих асуудлаар тодорхой санал боловсруулж, танилцуулсан байна. |
| 3 | Албан хаагчдыг орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийн хүрээнд орон сууц худалдан авч буй зарим албан хаагчид дэмжлэг үзүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоог гаргаж, 2022 оны төсөвт тусгуулах | Жилдээ | Төсөв шаардахгүй | Захиргаа, удирдлагын газар, Санхүүгийн хэлтэс | Орон сууц худалдан авсан албан хаагчдад мөнгөн дэмжлэг олгох санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгасан байна. |
| 4 | Албан хаагчийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх уралдаан, тэмцээн, арга хэмжээг зохион байгуулах | Уралдаан, тэмцээний төлөвлөгөөний дагуу | Спорт хамтлагийн түрээсийн орлого | Хангалт, үйлчилгээний хэлтэс, Спорт хамтлаг | Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг идэвхтэй, зохистой өнгөрүүлэх нөхцөл бүрдэнэ. |
| 5 | Албан хаагчдын гэр бүлийн хэрэгцээнд өмчлөх газар, зуслангийн газартай болгох чиглэлээр Хан-Уул дүүргийн Засаг дарга, | Жилдээ | Төсөв шаардахгүй | Захиргаа, удирдлагын газар | Төвийн албан хаагчдын 20 хүртэл хувьд өрхийн хэрэгцээний зуслангийн газар эзэмшүүлсэн байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | түүний Тамгын газарт хандан хүсэлт уламжлан шийдвэрлүүлэх | | | | |
| 6 | Албан хаагчийн ажлын байр, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах холбооны болон компьютер, бусад техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, цэвэрлэгээ үйлчилгээний материалаар хангах | Тухай бүр | 191,422,400 | Хангалт, үйлчилгээний хэлтэс | Албан үүргээ гүйцэтгэх тав тухтай орчин бүрдэж, ажлын үр дүн сайжирна. |
| 7 | Хөдөлмөр хамгааллын болон бусад зааварчилгаа өгөх, сургалт явуулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх | Улирал тутам | Төсөв шаардахгүй | | Албан хаагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангасан байна. |
| 8 | Албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, дүрэмт хувцас, ажлын байрны засвар үйлчилгээг хийх | Тухай бүр | 218,843,100 | | Албаны бэлэн байдлыг хангасан байна. |
| 9 | Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гаргаж, албан үүргээ үр дүнтэй биелүүлж амжилт гаргасан албан хаагчийг төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан болон холбогдох бусад цол, тэмдгээр шагнуулахаар тодорхойлох | Хагас, бүтэн жилдээ | Төсөв шаардахгүй | Захиргаа, удирдлагын газар | Ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн үнэлэмж дээшилнэ. |
| 10 | Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу албан хаагчдад ээлжийн амралтыг заавал биеэр эдлүүлэх, ажлын шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй тохиолдолд нөхөн амруулах | Ээлжийн амралтын хуваарийн дагуу | Төсөв шаардахгүй | Захиргаа, удирдлагын газар, Санхүүгийн хэлтэс | Албан хаагчид хууль тогтоомжийн хүрээнд амралтаа биеэр эдэлсэн, ажлын зайлшгүй шаардлагаар ажилласан тохиолдолд биеэр амраасан байна. |
| 11 | Хөдөлмөрийн дотоод журамд заасан тусламж, дэмжлэгийг албан хаагчдад олгох | Тухай бүр | 17,178,300 | | Журмын шаардлагад нийцсэн тусламж, тэтгэмжийг тухай бүр олгосон байна. |
| 12 | Хилийн боомт, орон нутаг дахь газарт ажиллаж байгаа ажилтанд 5 жил тутамд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгоход шаардагдах судалгааг гаргаж, зардлыг батлуулах, олгох | 7 дугаар сард | 313,000,000 | | Хилийн боомт, орон нутагт дахь албанд томилогдон ажиллаж буй албан хаагчдын нийгмийн баталгаа дээшилнэ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | Орон нутаг дахь газар, хилийн боомтод ажиллаж буй албан хаагчдын ажлын болон амьдрах байрны нөхцөлийг сайжруулах | Жилдээ | 24,000,000 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс Орон нутаг дахь нэгж | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа дээшилнэ. |
| 14 | Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу илүү цаг болон шөнийн цагаар ажиллах тохиолдолд биеэр нөхөн амраах, өөр аймаг, бүсэд ажиллахад албан томилолтыг олгох, албаны унаагаар хүргэх, авах зэрэг зохион байгуулалтыг авч хэрэгжүүлэх | Жилдээ | Албан томилолтын болон холбогдох зардал | Орон нутаг дахь нэгж | Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллах албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах ажилд ахиц гарсан байна. |
| Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр | | | | | |
| 15 | Албан хаагчийн эрүүл мэндэд анхаарч жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах | 3 дугаар улиралд | 24,480,000 | Захиргаа, удирдлагын газар, Санхүүгийн хэлтэс, Хангалт, үйлчилгээний хэлтэс | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна. |
| 16 | “Эрүүл аж төрөх ёс” сэдвийн хүрээнд нарийн мэргэжлийн эмчийг урьж, улиралд 1 удаа танилцуулга, мэдээлэл хийх, өвөл, хаврын улиралд “амин дэм, дархлаажуулалтын аян” зохион байгуулах | 1-3 дугаар улиралд | 150,000 | | Албан хаагчдын эрүүл мэндийн боловсролд ахиц гарна. |
| 17 | Цар тахлын үед халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор албан хаагчдыг вакцинд хамруулж, амны хаалт, бээлий, гар ариутгагч, нэг удаагийн хамгаалах хэрэгслээр хангах | Жилдээ | 42,758,000 | Санхүүгийн хэлтэс | Халдвар хамгааллын дэглэмийг мөрдсөн байна. |
| Батлагдсан төсөв | | | 2,254,151,600 | | |

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР